



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ГУРВАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 08 сарын 17 өдөр

Дугаар А/92

Пионер толгой

**Хөдөө аж ахуйн салбар болон төв суурингийн
өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг
хангах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 279 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 05 дугаар албан даалгавар, аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар албан даалгаврыг тус тус хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын 2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл хангуулах, хүлээн авах ажлын хэсгийг 1 дүгээр хавсралтаар, хөдөө аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар, сумын төв, суурин газрын өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөг 3 дугаар хавсралтаар, өрх, баг, байгууллагын аюулгүйн нөөцөд зайлшгүй бэлтгэх шаардлагатай өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэлтийн хуваарийг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Сумын 2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, биелэлтэд хяналт тавьж, захирамжийн хэрэгжилтийг баг, байгууллага бүрээр үр дүнг тооцон 10 дугаар сарын 01-ний дотор Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга Р.Гантулгад даалгасугай.

ОРЛОГЧ ДАРГА



Э.СҮГЛЭГМАА

642201405